



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/47

Баян-Өндөр сум

**Дархлаажуулалтын 10 хоногийг
зохион байгуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх хэсэг, Дархлаажуулалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2026 оны “Дархлаажуулалтын 10 хоног зохион байгуулах тухай” А/186 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Дархлаажуулалтын ээлжит 10 хоногийг 2026 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс 6 дугаар сарын 05-ны өдрүүдэд “Өнөөдрийн вакцин - Маргаашийн хамгаалалт” уриан дор харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулахыг сум, өрхийн эрүүл мэндийн төвийн нарт, мэргэжлийн арга зүйгээр ханган ажиллахыг Дархлаажуулалт, зоонозын халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн (П.Отгонбилэг)-т тус тус даалгасугай.
2. Энэхүү тушаалын хавсралтаар баталсан Дархлаажуулалтын 10 хоногийн мэдээлэл, сурталчилгааны төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн төв (Н.Мөнгөнцацралт), сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.
3. Дархлаажуулалтын 10 хоногоор заавал хийх товллын дархлаажуулалтаас хоцорсон 0-15 насны хүүхдийг нөхөн дархлаажуулах ажлыг эрчимжүүлж, дархлаажуулалтын ач холбогдол болон дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн талаар олон нийтэд зөв мэдээлэл түгээх, сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулахыг Олон нийттэй харилцах ажилтан(Ц.Намуундарь), бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, хууль эрх зүй, тусгай зөвшөөрөл хариуцсан ахлах мэргэжилтэн (Б.Уртнасан)-д даалгасугай.

ДАРГА



Д. МӨНХЦЭЦЭГ

Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны
01 сарын 28-ны өдрийн
1/4 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



**“ӨНӨӨДРИЙН ВАКЦИН - МАРГААШИЙН ХАМГААЛАЛТ” УРИАН ДОР
ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ДАРХЛААЖУУЛАЛТЫН 10 ХОНОГИЙН
МЭДЭЭЛЭЛ, СУРТАЛЧИЛГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах	Хамтрах
НЭГ. ДАРХЛААЖУУЛАЛТЫН АЧ ХОЛБОГДОЛ, ТОВЛОЛЫН ВАКЦИНЫ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ БЭЛТГЭЖ ТҮГЭЭХ				
1	Дархлаажуулалтын мэргэжилтнүүдийн туршлага солилцох 3 үеийн уулзалт зохион байгуулах	5 дугаар сарын 31	ЭМГ	СӨЭМТ
2	Дархлаажуулалтын ач холбогдлыг сурталчлах бүх насны төлөөллийг хамруулсан контент бэлтгэн түгээх	5 дугаар сарын 26-31	ЭМГ	СӨЭМТ
3	Дархлаажуулалтын ач холбогдол болон дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн талаар олон нийтэд зөв мэдээлэл түгээх, сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах	5 дугаар сарын 25-аас 6 дугаар сарын 5	ЭМГ	ЭМБ-ууд
4	Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн талаар мэдээлэл бэлтгэн түгээх	6 дугаар сарын 4-5	ЭМГ	ЭМБ-ууд
5	Дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх уриалга, сануулгат үгээх	6 дугаар сарын 4-5	ЭМГ	ЭМБ-ууд
ХОЁР. УЛААНБУРХАНЫ ДАРХЛААЖУУЛАЛТ				
6	Улаанбурханы дэгдэлтийн үеийн дархлаажуулалтын талаар мэдээлэл бэлтгэн түгээх	5 дугаар сарын 25-аас 6 дугаар сарын 5	ЭМГ	СӨЭМТ
7	6-8 сартай хүүхдийн улаанбурханы эсрэг дархлаажуулалт, 10-15 насны хүүхдийн улаанбурхан, улаануудын эсрэг нэмэлт дархлаажуулалтыг эрчимжүүлэх	5 дугаар сарын 25-аас 6 дугаар сарын 5	СӨЭМТ	ЭМГ, БГ
8	Насанд хүрэгчдийг сайн дурын дархлаажуулалтад хамруулах	5 дугаар сарын 25-аас 6 дугаар сарын 5	СӨЭМТ	ЭМГ
9	Улаанбурхан-гахай хавдар-улаануудын (УГУ) эсрэг вакцины ач холбогдлын талаар мэдээлэл бэлтгэн түгээх	5 дугаар сарын 26-31	ЭМГ	СӨЭМТ

ГУРАВ. ХҮНИЙ ПАПИЛЛОМА ВИРУСИЙН ЭСРЭГ ДАРХЛААЖУУЛАЛТ

10	Хүний папиллома вирусийн (ХПВ) вакцины ач холбогдол, сайн дурын дархлаажуулалтын талаар мэдээлэл бэлтгэн түгээх	5 дугаар сарын 27-28	ЭМГ	БГ, СӨЭМТ
11	Хүний папиллома вирусийн эсрэг дархлаажуулалтын хамралтыг эрчимжүүлэх сургалт 5-р ангийн багш нарт зохион байгуулах	5 дугаар сарын 27-28	ЭМГ	БГ, СӨЭМТ
12	Дархлаажуулалтын ач холбогдол сэдвээр 5-р ангийн сурагчдын дунд эссэ бичлэгийн уралдаан зарлах	5 дугаар сарын 25-аас 6 дугаар сарын 5	СӨЭМТ	ЭМГ, БГ
13	Хүний папиллома вирусийн эсрэг дархлаажуулалтын хамралтыг өндөр хувьтай зохион байгуулсан 5-р ангийн багшийг урамшуулах	5 дугаар сарын 25-аас 6 дугаар сарын 5	СӨЭМТ	ЭМГ, БГ

ДӨРӨВ. БУСАД ВАКЦИНЫ ЧИГЛЭЛЭЭР

14	Гепатит В вирусийн эсрэг вакцины ач холбогдол, сайн дурын дархлаажуулалтын талаар мэдээлэлийг түгээх	5 дугаар сарын 28-29	ЭМГ	ЭМБ-ууд
15	Сүрьеэгийн эсрэг (БЦЖ), В вируст гепатитын вакцины талаар мэдээллийг түгээх	6 дугаар сарын 2-3	ЭМГ	ЭМБ-ууд
16	Сахуу, татран, хөхүүл ханиадын вакцины талаар мэдээллийг түгээх	6 дугаар сарын 3-4	ЭМГ	ЭМБ-ууд
17	Халдварт саагийн эсрэг вакцин, цочмог сул саажилтын талаар мэдээллийг түгээх	6 дугаар сарын 4-5	ЭМГ	ЭМБ-ууд
18	Хемофилюс инфлюэнза В халдварын эсрэг вакцины талаар мэдээллийг түгээх	5 дугаар сарын 27-28	ЭМГ	ЭМБ-ууд